

БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫГ ИЛТГЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2021.11.25

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал			
1.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	2021 онд дэвшүүлсэн зорилгоо бүрэн хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг албан байгууллага, ард иргэдэд нээлттэй, шуурхай хүргэх үүднээс байгууллагын цахим хуудас /www.masm.su.gov.mn, Сүхбаатар стандарт, хэмжилзүйн хэлтэс, Сүхбаатар аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтэс гэсэн фейсбүүк хуудас болон мэдээллийн самбартаа холбогдох мэдээллүүдийг ойлгомжтой байдлаар байршуулсан.	100
2.	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн овог нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь, өргөдөл гомдлын сар улирлын мэдээг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байрлуулан тухай бүр шинэчлэх;	Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний баталгаажуулалт, хэмжүүр, хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, стандартын салбар сан зэрэг нэн шаардлагатай төрийн үйлчилгээний асуудал хариуцсан албан хаагчдын овог нэр, албан тушаал, хариуцсан ажил, ажиллах журам, харилцах утас, товч танилцуулга зэрэг мэдээллийг тусгайлан самбарт байршуулсан. Мөн өргөдөл гомдол хариуцсан ажилтны утасны дугаарыг /99139685/ мэдээллийн самбар болон байгууллагын web сайт дээр байршуулсан төдийгүй санал, хүсэлт, өргөдөл, гомдол авах дэвтэр, хайрцгийг үүдэн хэсэгт байршуулан иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг авч шуурхай барагдуулан ажиллаж байна. “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол шийдвэрлэх тухай” хуулийн дагуу манай хэлтэст 2021 оны хагас жилийн байдлаар 209 өргөдөл гомдол, санал хүсэлт ирсний 207 -г нь хуулийн хугацаанд	100

		шийдвэрлэсэн нь 99,0 хувийн үзүүлэлттэй байна. Хугацаа болоогүй 2 өргөдөл шийдвэрлэлтийн шатанд судлагдаж байна.	
3.	Төрийн үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байрлуулан тухай бүр шинэчлэх;	Бүтээгдэхүүн баталгаажуулалт, хэмжих хэрэгслийн баталгаажуулалт хийлгэхэд шаардлагатай бүрдүүлэх материал, тэдгээрийн төлбөрийн хэмжээ, улсын баталгаажуулалтанд заавал хамрагдах хэмжих хэрэгслийн жагсаалт, үндэсний болон олон улсын стандартын 2021 оны шинэчлэгдсэн каталоги, стандартын үнэ зэргийг цахим хуудсанд https://masm.gov.mn/sba/ , /www.masm.su.gov.mn, Сүхбаатар Стандарт, хэмжилзүйн хэлтэс, Сүхбаатар аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтэс гэсэн фейсбүүк хуудас болон байгууллагын мэдээллийн самбарт тод харагдахуйц байршуулсан.	100
4.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа Монгол Улсын “Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай”, “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ итгэмжлэлийн тухай” хууль болон байгууллагын онцлогт тохируулан боловсруулж Аймгийн засаг даргын захирамжаар батлуулсан дүрэм журмыг жагсаалтаар гаргаж бүрэн эхээр нь болон иргэдэд үзүүлэх төлбөртэй ажил үйлчилгээний жагсаалтаас гол зүйлийг түүвэрлэж, мэргэжлийн үг хэллэгийг иргэдэд ойлгомжтой байдлаар ил тод байдлын самбар болон цахим хуудсанд байршуулсан.	100
5.	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;	СХЗГ-н даргын 2020 оны 3-р сарын 4-ний өдрийн А/54 тоот тушаалаар батлагдсан Стандартчиллын 2020-2021 оны хөтөлбөрт тусгагдсан стандартын төслүүдэд санал авах зорилгоор хэлтсийн цахим хуудсанд байршуулж, холбогдох газруудад төслийг цахимаар мэдээлж ирсэн санал болон хэлтсээс гарсан саналыг СХЗГ-т явуулсан. Мөн салбарын хэмжээнд мөрдөгдөх “CS -11-0182:2021 Стандарт, хэмжилзүйн газрын үйл ажиллагаа болон албан хаагчдад тавигдах шаардлага” байгууллагын стандартад саналаа явуулсан.	98

6.	<p>Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;</p>	<p>Ковид-19 цар тахал тархсантай холбогдуулан ISO/PAS 45005:2021 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежмент стандартыг байгууллага дотроо боломжоороо хэрэгжүүлэхийг зорин ажиллаж байна. Тухайлбал:</p> <p>Үйлчилгээг цахимжуулах, илүү шуурхай, нэг дор олон хүнийг хамруулах зорилгоор 7 сургалтыг цахим хэлбэрээр хийж 328 хүнд 8 сэдвээр мэдээлэл өгч Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг сургалтанд оролцогчдоос түүвэрлэн цахим хэлбэрээр авсан. Мөн тус судалгааг фейсбүүк хаягуудад байршуулан, 4 иргэнээс цахимаар авсан бөгөөд цахим судалгаанд хамрагдсан иргэд байгууллагын үйл ажиллагааг 88.7% гэж дүгнэжээ.</p> <p>Иргэдэд шаардлагатай төрийн үйлчилгээний мэдээллийг орон нутгийн BBS телевиз болон цахим хэлбэрээр дамжуулан мэдээллийг хүргэж байна. Мөн шинээр болон шинэчлэгдэн батлагдсан стандартын талаархи мэдээллийг холбогдох байгууллагуудад цахим хэлбэрээр мэдээллийг хүргэж стандартын захиалга авч ажиллаж байна. Мөн иргэд www.estandard.mn сайтнаас шаардлагатай стандартаа цахимаар захиалж, хэлтэст ирэлгүйгээр байгаа газраасаа өөрсдөө хэвлэж авах боломж бүрдсэн.</p> <p>Мөн үйлчлүүлэгчтэй бэлэн мөнгө солилцохоос зайлсхийн цахим банкыг түлхүү ашиглаж байна.</p>	98
7.	<p>Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;</p>	<p>Байхгүй</p>	

8.	<p>Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;</p>	<p>Стандарт, хэмжилзүйн хэлтсийн даргын 2021 оны 11-р сарын 8-ны өдрийн А/03 тоот тушаалаар аймгийн орон тооны бус баталгаажуулалтын зөвлөлийг Стандарт, хэмжилзүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ хариуцсан тасгийн дарга, Мэргэжлийн хяналтын газрын Хүнс, худалдаа хариуцсан ахлах байцаагч, Сүхбаатар аймаг дахь Хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэгийн дарга гэсэн холбогдох мэргэжлийн байгууллагын мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнтэй байгуулж Ñòàíäàðð÷èèàè, òíðèðèùí çíýèäýý, áçòýýääýðççí àæèè çèè÷èèäýýíèé ÷àíàðùí áàðàèääàæòóèèèðàíä àæ àðóéí íýäæèéí ýèññðòùí áçòýýääýðççí áíèíí àìðñäùí áçòýýääýðççí /ãððèè, ãððèèàí áçòýýääýðççí, àð, àðàí áçòýýääýðççí цайрын баяжмал, хүрэн нүүрс жонш/, болон çèè÷èèäýýä /зоогийн газар баар, хүнсний дэлгүүр, зочид буудал жуулчны бааз, үсчин, халуун ус, саун, гоо сайхны газар, ахмадын амралтын газар, бялдаржуулах төв, авто угаалга/ òíðèðèùí çíýèäýýíä òàìðóóèè ñòàíäàððòùí øààðäèèäà òàíäàñàí áçòýýääýðççí, çèè÷èèäýýä баталгаажуулалтын зөвлөлийн хурлаар хэлэлцэн “Òíðèðèùí äýð÷èèäýý” îèäíæ çèè÷èèðэг бөгөөд “Тохирлын гэрчилгээ” эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг бүртгэлжүүлдэг.</p>	100
9.	<p>Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх;</p>	Байхгүй	
10.	<p>Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах, хяналт тавих үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангасан байдал, үр дүнг сумын нийт иргэдэд ил</p>	Хамааралгүй	

	тод мэдээлсэн байдал		
Хэсгийн дундаж хувь:			99.4
Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал;			
1.	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;	<p>Архив, хүний нөөц, бичиг хэргийн ажилтан Ч.Соёлцэцэг 2020 оны 4 –р сарын 13-аас 2020 оны 9-р сарын 09 хүртэл жирэмсний амралттай байсан тул хэлтсийн даргын 2020 оны 04-р сарын 13-ны өдрийн Б/07 тоот “Ажил хавсран гүйцэтгүүлэх тухай” тушаал гарч улсын шалгагч Э.Цогдэлгэрийг цалингийн 30%-р цалинжуулж уг ажлын байрыг хавсран гүйцэтгүүлж байсан. Мөн Ч. Соёлцэцэг үйлчлэгчийн ажлыг хавсран гүйцэтгэдэг байсан бөгөөд хэлтсийн даргын 2020 оны 04-р сарын 13-ны өдрийн Б/08 тоот “Ажил хавсран гүйцэтгүүлэх тухай” тушаал гарч стандартын салбар сангийн мэргэжилтэн Б.Мөнхжаргалыг цалингийн 30%-р цалинжуулж уг ажлын байрыг хавсран гүйцэтгүүлж байна. 2020 оны 09-р сарын 09-ний өдрийн “Чөлөө олгох тухай” хэлтсийн даргын тушаал гарч Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.1 дэх заалт, өөрийн хүсэлтийг нь үндэслэн Ч.Соёлцэцэгт 2020 оны 09-р сарын 09-ний өдрөөс эхлэн 2021 оны 09-р сарын 09 өдөр хүртэл 1 жилийн хугацаатай чөлөө олгосон тул дээрхи 2 ажилтан тус хугацаанд тус тусын ажлыг үргэлжлүүлэн хавсран гүйцэтгэж байсан бөгөөд Ч.Соёлцэцэгийн чөлөөний хугацаа дууссан тул 2021 оны 09-р сарын 13-ны өдрийн Б/05 тоот “Хүүхэд асрах чөлөөг дуусгаж, албан тушаалд нь үргэлжлүүлэн ажиллуулах тухай” хэлтсийн даргын тушаал гарч ажилдаа эргэн орсон.</p> <p>Мөн Хэлтсийн нягтлан бодогч Бя.Мөнхжаргал өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн тул Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.1 дэх заалтыг үндэслэн хэлтсийн даргын 2021 оны 07-р сарын 09-ны өдрийн Б/02 тоот “Ажлаас чөлөөлөх тухай” хэлтсийн даргын тушаал гарч</p>	100

		<p>Бя.Мөнхжаргалыг ажлаас чөлөөлсөн бөгөөд Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалтыг үндэслэн 2021 оны 07-р сарын 19-ний өдрийн Б/03 тоот “Ажилд томилох тухай” тушаал гарч О.Эрдэнэцэцэгийг нягтлан бодогчоор 2021 оны 08-р сарын 01-ний өдөр хүртэл түр томилсон бөгөөд 2021 оны 8-р сарын 02-ны өдрийн Б/04 тоот хэлтсийн даргын “Ажилд томилох тухай” тушаал гарч 2021 оны 08-р сарын 01-ний өдрөөс эхлэн О.Эрдэнэцэцэгийг нягтлан бодогчоор томилсон.</p>	
2.	<p>Албан хаагчийн ёс зүйн дүрэм, байгууллагын ёс зүйн хорооны жилийн ажлын төлөвлөгөө, тайланг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байрлуулсан байх;</p>	<p>Төрийн албан хаагчдын ёс зүй, хариуцлага, нэр хүндийг дээшлүүлэх “Төрийн захиргааны албан тушаалтны ёс зүйн хэм хэмжээний тухай дүрэм”-ийг мөрдлөг болгон Стандарт, хэмжилзүйн хэлтсийн албан хаагчдын ёс зүйн дүрмийг шинээр боловсруулан ажилтан албан хаагчдын ажлын байранд, ил тод байдлын самбар болон цахим хуудсанд байршуулан, мөрдөн ажиллаж байна. Мөн тусгайлан төрийн албаны зарчим, ёс зүйг бичсэн самбарыг өрөө бүрт байршуулсан.</p> <p>Хэлтсийн даргын 2019 оны 09-р сарын 18-ны өдрийн А/04 тоот тушаалаар байгууллагын ёс зүйн хороог 1 дарга, 2 гишүүн буюу нийт 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан ба хийх ажлын төлөвлөгөөг гарган үйл ажиллагаагаа тогтмолжуулан ажиллаж байна.</p> <p>Стандарт, хэмжилзүйн газраас баталсан салбарын хэмжээнд мөрдөгдөх CS -11-0182:2021 Стандарт, хэмжилзүйн газрын үйл ажиллагаа болон албан хаагчдад тавих шаардлага стандартыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.</p>	100
3.	<p>Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;</p>	<p>2021-2024 оны Хүний нөөцийн хөгжлийн тэргүүлэх чиглэл, стратегийн зорилт, хэрэгжүүлэх чиглэлийг тодорхойлж хэлтсийн даргаар батлуулан, хэлтсийн мэдээллийн самбарт ил тод байршуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>	95
4.	<p>Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний</p>	<p>Хэлтсийн www.masm.su.gov.mn цахим хуудсанд Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж</p>	98

	талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	байгаа арга хэмжээний талаар ойлгомжтой байдлаар тогтмол оруулж байна.	
5.	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр байгууллагын дотоод журамд өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг зохион байгуулсан байдал, энэ талаар цахим хуудсандаа байрлуулан мэдээлж байх;	Хэлтсийн бүх ажилчдаас санал авч, гарсан саналыг хэлэлцэн, 2020 оны 10-р сарын 07-ны өдрийн А/04 тоот “Дотоод журмыг шинэчлэн батлах тухай” хэлтсийн даргын тушаал гарч 7.4.6, 7.4.8 дахь заалтуудад өөрчлөлт оруулан, мэдээллийн самбарт байршуулан, 2019 оны 09-р сарын 18-ны өдөр Стандарт, хэмжилзүйн хэлтсийн даргын А/05 тоот тушаалаар баталсан дотоод журмыг хүчингүй болгосон. 2021 онд тус журамд өөрчлөлт ороогүй.	95
Хэсгийн дундаж хувь: 97.6%			
Гурав: Шилэн дансны хөтлөлт			
Төсөв /Гүйцэтгэл:			
1.	Дараа жилийн төсвийн төсөл /бүтэн жилээр/	2022 оны төсвийн төслийг СХЗГазарт Chimgee@masm.gov.mn цахим хаягаар хүргүүлсэн. Хэлтсийн ирэх жилийн нийт төсөв 316682,5 мянган төгрөг байхаар төлөвлөөд байна.	100
2.	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт /бүтэн жилээр, хагас жилээр, улирал бүр, сар бүр/	Батлагдсан төсөв 2 удаа өөрчлөгдсөн бөгөөд цалингаас бусад зардал хасагдсан. Хэмнэлт 11018,1 мянган төгрөг, үүний 3065,5 мянган төгрөг нь цалингийн зардал 1952,0 мянган төгрөг нь томилолтын зардал, 1595,1 мянган төгрөг байр ашиглалттай холбоотой зардал , 4405,5 мянган төгрөг нь бараа үйлчилгээний бусад зардал юм. Хэмнэлтийн шалтгаан нь 1 ажилтан хүүхэд асрах чөлөөтэй байсан. Мөн КОВИД-19 цар тахлын улмаас сумдын ээлжит баталгаажуулалтын ажил хожимдож хийгдсэн.	100
3.	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт /тухай бүр/	ЗГ-аас төсөвт өөрчлөлт оруулж цалингаас бусад бүх зардлыг танасан. Урсгал засвар, багаж техник хэрэгслийн зардлыг бүрэн татсан байна.	100

4.	Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан /бүтэн, хагас жилээр/	Ковид-19 цар тахлын улмаас 2020 оны төлөвлөгөөт орлого 20 сая төгрөгөөр давсан боловч зарцуулах эрх, санхүүжилт нь төсөвт орж ирээгүй болно. 2021 оны орлогын төлөвлөгөө 11 дүгээр сарын байдлаар хэтрэлтгүй байна.	100
5.	Хандив тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан / хагас, бүтэн жилээр/	Байхгүй	
6.	Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ / тухай бүр/	Байхгүй	
7.	Санхүүгийн тайлан /хагас, бүтэн жилээр/	Хагас жилийн санхүүгийн тайланг 2021 оны 7-р сарын 05-ны дотор гаргаж СХЗГ болон бусад байгууллагад тайлагнаж ажилласан.Мөн 2021 оны 3 дугаар улирлын тайланг 10 дугаар сарын 15 ны дотор гаргаж СХЗГазарт хүргүүлэн. Мөн И-тайлан системд шивж оруулсан.	100
8.	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	Төрийн аудитын газрын 2021 оны 2 дугаар сарын 19 ний өдрийн 38 тоот албан тоотоор манай байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгүй итгэл үзүүлэн “Зөрчилгүй санал дүгнэлт” авсанд тооцсон.	100
Хэсгийн дундаж хувь: 100%			
Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт			
1.	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан /бүтэн жилээр/		
2.	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл /бүтэн жилээр, сар бүр/	Байхгүй	

3.	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл /тухай бүр/	Байхгүй	
4.	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилт, нийлүүлэгчийн нэр хаяг /тухай бүр/	Байхгүй	
Хэсгийн дундаж хувь: 100%			
Бусад			
1.	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8,9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл. /тухай бүр/	Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт маягтын дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг дарга нягтлан бодогч нар гарын үсгээр баталгаажуулан pdf файлаар оруулж хэвшсэн.	100
2.	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудит, бусад хяналт шалгалтын дүн, дүгнэлт, зөвлөмж түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан /бүтэн жилээр, тухай бүр/	Байхгүй	
3.	Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт /сар бүр/	Байхгүй	
4.	Бонд зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр /тухай бүр/	Байхгүй	
Хэсгийн дундаж хувь			100

Хэрэгжилтийн дундаж хувь		99.4

Ил тод байдлын нэгтгэсэн

Ахлах мэргэжилтэн

Ц.Өлзийжаргал

Хянасан:

Хэлтсийн дарга

Д.Эрдэнэбат